



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/04

Цэнхэрмандал сум

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогод бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 238 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 77 дугаар зүйлийн 77.2.1 дэхь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2.1, 2.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогод бэлтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Сугармаа	- Арга зүйч
Нарийн бичгийн дарга:	Д.Ганчимэг	- Нягтлан бодогч
Гишүүд:	Г.Түвшинзаяа	- Хөгжмийн багш
	Г.Энхчимэг	- Багшийн туслах
	С.Занабаяр	- Багшийн туслах
	Э.Цэцэгням	- Үйлчлэгч
	Ч.Сарангуа	- Жижүүр

2. Холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэгт амжилттай бэлтгэн оролцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Сугармаа)-д, хариуцлага санаачлагатай ажиллахыг нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА